



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Стратеги, төлөвлөгөө батлах
тухай


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1 дэх заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн 2015-2020 оны стратеги”-ийг нэгдүгээр, “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хоёрдугаар, “Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн чиглэл”- ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр улсын төсөв болон олон улсын байгууллага, хандивлагчидтай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Н.Цогбадрах), Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080285

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 19 өдрийн
16 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН СТРАТЕГИ (2015-2020 ОН)

Нэг. Үндэслэл

Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ) нь 1931 онд “Тарваган тахлын лаборатори” нэртэй байгуулагдсан бөгөөд үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ нь өргөжсөөр Засгийн газрын 2012 оны 231 дугаар тогтоолоор “Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төв” болон ажиллаж байна.

Зоонозын халдварт өвчний хяналт сэргийлэлт, хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл нь “Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төвийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө”, “Шинэ болон сэргэж буй халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан боловч хэрэгжилтийн түвшин төдийлөн сайн биш байна.

Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг өвчний байгалийн голомтын тархалт, хүн амын өвчлөлийн үзүүлэлт зэрэг хүчин зүйлийг харгалзан аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны чиглэлийг ялгаатай тогтоож, бүсчлэн хөгжүүлэх, зүүн бүсийн болон Төв аймагт Зоонозын өвчин судлалын төвийг шинээр байгуулах шаардлагатай байна.


Мөн 2013 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчний 1.2 хувийг зоонозын халдварт өвчин эзэлж байгаа боловч үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүсгэх эрсдэл бүхий, нутагшмал тарваган тахал, боом, галзуу, хачгаар дамжих халдвар, баруун Нилийн чичрэг, бэтэг зэрэг өвчний тохиолдол жил бүр бүртгэгддэг, дэлхий дахинд шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний зонхилох хувийг зоонозын халдварт өвчин эзэлж байгаа нь тандалт судалгааг үе шаттай бэхжүүлж, шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах шаардлагыг бий болгож байна.

Тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчний жагсаалтыг шинэчлэх, тэдгээрийн эрт оношилгоо, хяналт сэргийлэлтийн арга хэмжээг боловсронгуй болгох, лабораторийн оношилгооны нэр төрөл, чанар, биоаюулгүй байдлыг лавлагаа төвийн түвшинд хүргэх, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, түүнчлэн хамтын ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тогтоох, үр дүнг шийдвэр гаргалтад ашиглах замаар үр өгөөжийг сайжруулах нь чухал байна.

Энэхүү стратеги нь 2020 он хүртэл Монгол улсын хэмжээнд зоонозын өвчний өвчлөл, эндэгдлийг бууруулахад чиглэсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болно.

Хоёр. Зоонозын өвчний ангилал

- **Нутагшмал:** тарваган тахал, боом, галзуу, бруцеллёз, лептоспириоз, пастереллёз, листериоз
- **Дамжуулагчаар дамждаг өвчнүүд:**
 - Хачгаар дамждаг: хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз, ку чичрэг, хулгана тахал, Крым-Конгийн цусархаг чичрэг, анаплазмоз/эрлихиоз, бабезиоз
 - Шумуулаар дамждаг: баруун Нилийн чичрэг, Япон энцефалит, денге чичрэг, хумхаа
- **Хайхардаггүй өвчин (neglected zoonotic diseases):** татран, бэтэг, токсоплазмоз, криптоспиридиоз, лейшманиоз, ям/хуурмаг ям, хуурмаг сүрьеэ, ханта вирусын халдвар
- **Зөөвөрлөгддөг өвчнүүд:** холер, шувууны томуу



Гурав. Стратегийн зорилго, зорилтууд

Хөгжлийн зорилго: Олон улсын чиг хандлагатай уялдуулан, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн тогтолцоог бүрдүүлж, тогтвортой хөгжүүлэх		
Зорилт	Дэд зорилт	Хүрэх үр дүн
Зорилт 1. Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн тогтолцоог бэхжүүлэх	1.1 Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэлхийн болон бүсийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох 1.2 Монгол улсын бүсчилсэн хөгжилд түшиглэн зоонозын өвчин судлалын байгууллагуудыг бүсчлэн хөгжүүлэх замаар тусламж үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none">▪ Орчин үеийн чиг хандлагыг тусгасан эрх зүйн тогтолцоо сайжирч, хяналт, сэргийлэлтэд хамруулах зоонозын өвчний хүрээ, үйл ажиллагааны чиглэл өргөжинө.▪ Бүс нутгийн хүн амд үзүүлэх зоонозын өвчний тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, Зоонозын өвчин судлалын төвүүдийн уялдаа холбоог сайжруулах, төсөв санхүүг оновчтой зарцуулах нөхцөл бүрдэнэ.
Зорилт 2. Зоонозын өвчний эрсдлийн үнэлгээнд суурилсан тандалт, хариу арга хэмжээний цогц бодлогыг хэрэгжүүлэх	2.1 Тандалтын тогтолцооны чадавх, хариу арга хэмжээний бэлэн байдал, нөөцийг шинэчлэн төвлөрүүлэх 2.2 Хүрээлэн буй орчны тандалт, хяналтын тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх 2.3 Зоонозын өвчний урьдчилан сэргийлэлтийн механизмыг боловсронгуй болгох, үр өгөөжийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none">▪ Зоонозын өвчний аюул, эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээний чадавх сайжирна▪ Хүрээлэн буй орчны нөлөөлөлд эрсдлийн үнэлгээ хийнэ.▪ Хүн амын мэдлэг, дадал, хандлага өөрчлөгдөж, эрсдэлт зан үйл өөрчлөхөд нөлөөлнө.

	2.4. “Нэг эрүүл мэнд” салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх	<ul style="list-style-type: none"> Зоонозын халдварт өвчний салбар хоорондын хамтын ажиллагаа тогтворжсон байна.
Зорилт 3. Тандалтын хөгжлийн бүтэц, чиг хандлагатай уялдуулан зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн технологид өөрчлөлт гаргах	<p>3.1. Нутагшмал зоонозын өвчний эрсдлийн үнэлгээнд суурилсан тандалтын тогтолцоог хөгжүүлэх</p> <p>3.2. Хачгаар дамждаг өвчний тандалт, хяналтын тогтолцоог бий болгох</p> <p>3.3. Шумуулаар дамждаг болон хайхрагддаггүй зоонозын өвчний тандалтын тогтолцоог бүрдүүлэх</p> <p>3.4. Бруцеллёз өвчний тандалтын тогтолцоог бий болгох, оношилгоо эмчилгээний чанарыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> Байнгын тандалт, хяналтад байх нутагшмал болон хачгаар дамждаг өвчний тоо нэмэгдэж, эрсдлийг бууруулах арга хэмжээ сайжирна. Хайхардаггүй болон шумуулаар дамждаг өвчний тандалтын тогтолцоог бий болгосноор хяналт, сэргийлэлт сайжирна. Бруцеллёз өвчний тандалтын тогтолцоог бий болгосноор хяналт сэргийлэлт, эрт оношилгоо, эмчилгээний чанар сайжирна.
Зорилт 4. Лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээг хангах, чадавхийг дээшлүүлэх	<p>4.1. Лабораторийн чадавхийг сайжруулах замаар хүн амд үзүүлэх чанартай лавлагаа тусламж, үйлчилгээг бэхжүүлэх</p> <p>4.2. Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх</p> <p>4.3. Лабораторийн биоэрсдлийн менежментийг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> Лабораторийн тусламж, үйлчилгээнд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, хүн амд үзүүлэх лавлах үйлчилгээний үр дүнг сайжирна.
Зорилт 5. Судалгаа, шинжилгээнд шинэ дэвшилтэт арга, технологи нэвтрүүлэх замаар нотолгоонд суурилсан шийдвэр гаргах	<p>5.1. Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах хөшүүргийг бий болгох</p> <p>5.2. Зоонозын өвчний талаарх судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх</p> <p>5.3. Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн чадавх сайжирч, тогтвор суурьшилтай ажиллуулсан байна. Судалгааны чадавх, материаллаг бааз бэхжинэ.
Зорилт 6. Биоаюулгүй байдал, биохамгааллын чадавхийг сайжруулан, биотерроризмын тандалтын тогтолцоог	6.1. Биотерроризмын тандалтын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> Биотерроризмын тандалтын тогтолцооны эхлэл тавигдаж, тэргүүлэх чиглэл тодорхойлогдсон байна. Биотерроризмын бэлэн байдал, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх нэгж байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлсэн байна.

нэвтрүүлэх	6.2. Биоаюулгүй байдал, биохамгааллын арга хэмжээний чадавхийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Биотерроризмын бэлэн байдал, нөөцийн тасралтгүй хангалтын тогтолцоог бүрдсэн байна.
	6.3. Биоэрсдлийн менежментийн сайжруулах	<ul style="list-style-type: none"> Сорьцын менежментийн тогтолцоог шинэчилж, тээвэрлэлт, хадгалалтын аюулгүй байдлыг хангасан байна. Биоаюулгүй ажиллагааны зэрэглэлд нийцүүлэн бүх шатны лабораторийн чадавхийг бэхжүүлсэн байна.

Дөрөв. Санхүүжилт

Стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, дотоод гадаадын аж ахуйн нэгж байгууллага, хандивлагч орны тусламж, дэмжлэг байна.

Тав. Хяналт үнэлгээ, шалгуур үзүүлэлт

Стратеги, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд суурилсан явцын болон гүйцэтгэлийн хяналт үнэлгээг ажлын хэсэг байгуулан хэрэгжүүлнэ. Хяналт, үнэлгээний ажлын хэсэг нь тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр гүйцэтгэлийн үнэлгээ хийж, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлээр тайлагнана.


Шалгуур үзүүлэлт:

	№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2014 он)	Хүрэх түвшин	
				2017	2020
Зорилт 1	1	Шинэчилсэн болон шинээр батлуулсан эрх зүйн баримт бичгийн (стандарт, удирдамж, САА, тохиолдлын тодорхойлолт, бусад) тоо	48	58	68
	2	Орон нутаг дах ЗӨСТ-ийн тоо	14	18	22
	3	Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн төвийн тоо	-	3	5
	4	Зоонозын өвчин судлалын байгууллагуудын (15) улсын төсвийн санхүүжилтийн өсөлт (хувиар)	~4 тэрбум	30%-иар нэмэгдүүлнэ	40%-иар нэмэгдүүлнэ
Зорилт 2	5	Эрсдлийн үнэлгээнд тогтмол ашиглагдах орчны мониторингийн үзүүлэлтийн төрлийн тоо	1	2-3	4-5
	6	ЭМСЯ-ны Шуурхай удирдлагын төвд тогтмол мэдээлдэг үйл явдал, өвчний төрлийн тоо	-	6	10

	№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2014 он)	Хүрэх түвшин	
				2017	2020
	7	Тандалтын тогтолцоонд ашиглах вебэд суурилсан программ хангамжийн тоо	-		1
	8	Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөцийн хангалтын хувь Эд зүйлсийн төрөл, тоогоор Мөнгөн дүнгээр	20% 13%	50% 50%	100% 100%
	9	Батлагдсан оношилгоо эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамжийн тоо	8	12	17
	10	Мэдээлэл, сургалт сурталчилгаа, эрсдлийн үеийн харилцаа холбооны нэгжийн тоо	-	4	22
	11	Эдийн засгийн үр ашгийн судалгаа хийгдсэн вакцины төрлийн тоо	-	1	2
Зорилт 3	12	Зоонозын шалтгаант өвчний эрт илрүүлэлтийн судалгаа хийгдсэн өвчний эзлэх хувь	-	15%	40%
	13	Халдварт өвчний тандалтын нэгдсэн тогтолцоонд шинээр мэдээлэгдсэн зоонозын шалтгаант хамшинж/сэжигтэй тохиолдлын тоо (тэргүүлэх чиглэлийн 17 өвчнөөс)	7	10	15
	14	Эмнэлэгт суурилсан тандалтад хамруулсан өвчний төрөл	3	5	10
	15	Бруцеллёзын тандалтын нэгжийн тоо	0	18	22
Зорилт 4	16	Лабораторийн шинжилгээнд шинээр нэвтрүүлсэн арга, аргачлал	-	10	20
	17	Тэжээлт орчин, биобэлдмэлийн үйлдвэрлэлд шинээр болон шинэчлэн нэвтрүүлсэн техник, технологийн тоо	-	3	5
	18	Лабораторийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн итгэмжлэл	-	1	1
	19	Биоаюулгүй ажиллагааны 2-р зэрэглэлийн лабораторийн тоо	1	3	5
Зорилт 5	20	Хүний нөөцийн хангалт (нийт ажилтны тоо)	370	400-450	
	21	Нийт ажилтны дунд мэргэжлийн боловсон хүчний эзлэх хувь	46%	50%	60%
	22	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг, цолтой мэргэжилтний эзлэх хувь	15%	25%	40%
	23	Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо/төрөл	-	2	4

	№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт (2014 он)	Хүрэх түвшин	
				2017	2020
Зорилт 6	24	Эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр хамтран ажиллах гэрээ бүхий байгууллагын тоо (жилд байгуулсан гэрээний тоо)	6-8	8-10	10-15
	25	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж, хэвлүүлсэн илтгэл, өгүүллийн тоо (жилийн дундаж)	20	1.5 дахин	2 дахин
	26	Биотерроризмын тандалтын чиглэлээр батлагдсан эрх зүйн баримт бичгийн тоо	-	2-3	2-3


Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 02 өдрийн
86 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2015-2020 ОН)

Зорилт 1. Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн тогтолцоог бэхжүүлэх							
№	Үйл ажиллагаа	Он					
		2015	2016	2017	2018	2019	2020
<i>Дэд зорилт 1.1. Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэлхийн болон бүсийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох</i>							
1	Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн бодлогын баримт бичигт үнэлгээ хийх						
2	Зоонозын өвчнүүдийн тохиолдлын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах						
3	Зонхилон тохиолдох зоонозын өвчний оношилгоо эмчилгээ, тандалтын стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах						
4	Нутагшмал, дамжуулагчаар дамждаг, хайхардаггүй зоонозын өвчнүүдийн хяналт, сэргийлэлтийн удирдамжийг шинэчлэх						
5	Хүн амын дунд зоонозын өвчний тархалтыг тогтоох эрт илрүүлэг (screening) хийх заавар, эрсдлийн үнэлгээний аргачлал боловсруулах						
6	Зоонозын өвчний холбогдолтой нэр томъёоны стандарт боловсруулах						
7	Өвчний онцлогыг тусгасан өвөрмөц стратеги төлөвлөгөө боловсруулах						
<i>Дэд зорилт 1.2. Монгол улсын бүсчилсэн хөгжилд түшиглэн зоонозын өвчин судлалын байгууллагуудыг бүсчлэн хөгжүүлэх замаар тусламж үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх</i>							
8	Орон нутаг дахь Зоонозын өвчин судлалын төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт боловсруулах						
9	Бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрөлжүүлэх, онцлогийг тодорхойлоход чиглэсэн тогтолцооны судалгааны арга зүйг боловсруулах						

10	Орон нутаг дах Зоонозын өвчин судлалын төвүүдийг бүсчилэн тогтолцооны судалгаа хийх								
11	Зоонозын өвчин судлалын бүсийн загвар төв, сүлжээ байгуулах журмыг боловсруулах								
12	Зоонозын өвчний хяналт сэргийлэлтийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, Зоонозын өвчин судлалын байгууллагуудын улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар шийдвэр гаргагчдад зориулсан ухуулга, нөлөөллийн ажлыг зохион байгуулах								
Зорилт 2. Зоонозын өвчний эрсдлийн үнэлгээнд суурилсан тандалт, хариу арга хэмжээний цогц шинэчлэлийг төлөвшүүлэх									
<i>Дэд зорилт 2.1. Тандалтын тогтолцооны чадавх, хариу арга хэмжээний бэлэн байдал, нөөцийг шинэчлэн төвлөрүүлэх</i>									
13	Тэргүүлэх чиглэлийн зоонозын өвчний жагсаалтыг шинэчлэн боловсруулах								
14	Тарваган тахал, боом зэрэг нутагшмал зоонозын өвчний цогц эрсдлийн үнэлгээ хийж хэвшүүлэх								
15	Боом өвчний голомтын судалгааг үе шаттай хийх, газарзүйн мэдээллийн системд оруулах								
16	Боом, тарваган тахлын вакцины эдийн засгийн үр ашгийн судалгаа хийж, үр дүнг тооцох								
17	Халдварт өвчний бэлэн байдлын нөөцийн агуулах бариулах								
18	Халдварт өвчний бэлэн байдлын нөөцийн интернэтэд суурилсан бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх								
19	Зоонозын халдварт өвчний дархлаажуулалтын талаарх гарын авлага боловсруулах, түгээх								
20	Зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтад тарилгын картыг нэвтрүүлэх								
21	Орон нутаг дахь төвүүдийг хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах								
<i>Дэд зорилт 2.2. Хүрээлэн буй орчны тандалт, хяналтын тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх</i>									
22	Хүрээлэн буй орчны мониторинг үнэлгээ хийдэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ								





	байгуулах							
23	Хачиг, шумуулаар дамждаг өвчний сэргийлэлтэд дайжуулагч (spray) хэрэглэх талаар судалгаа хийх							
24	Төвлөрсөн хүн ам суурьшсан бүс нутагт хачгийн устгалыг туршилтаар хийх							
<i>Дэд зорилт 2.3. Зоонозын өвчний урьдчилан сэргийлэлтийн механизмыг боловсронгуй болгох, үр өгөөжийг дээшлүүлэх</i>								
25	Эрсдлийн үеийн харилцаа холбооны багийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах							
26	Зорилтот бүлгийн хүн амд зориулсан зонхилон тохиолдох зоонозын өвчин, түүнээс сэргийлэх сургалт сурталчилгааны материалыг боловсруулах, хэвлүүлэх, түгээх							
<i>Дэд зорилт 2.4. "Нэг эрүүл мэнд" салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх</i>								
27	Салбар хоорондын мэдээлэл солилцох журам боловсруулан, холбогдох яамдаар батлуулан, хэрэгжүүлэх							
28	Мал амьтнаас хүнд дамждаг халдварт өвчний хамтарсан судалгаа хийх							
29	Зоонозын халдварт өвчний дэгдэлтэд хамтран ажиллах, хариу арга хэмжээг зохион байгуулах							
30	Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн чиглэлээр үндэсний зөвлөлгөөн, дадлагажуулах сургалт зохион байгуулах							
Зорилт 3. Тандалтын хөгжлийн бүтэц, чиг хандлагатай уялдуулан зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн технологийн хэрэгжилтэд эрсөөрчлөлт гаргах								
<i>Дэд зорилт 3.1. Нутагшмал зоонозын өвчний эрсдлийн үнэлгээнд суурилсан тандалтын тогтолцоог хөгжүүлэх</i>								
<i>Дэд зорилт 3.2. Хачгаар дамждаг өвчний тандалт, хяналтын тогтолцоог бий болгож, төлөвшүүлэх</i>								
<i>Дэд зорилт 3.3. Шумуулаар дамждаг болон хайхрагддаггүй зоонозын өвчний тандалтын тогтолцоог бүрдүүлэх</i>								
31	Бруцеллёз, листериоз, хачиг боррелиоз, токсоплазмоз, лептоспириоз, хачиг риккетсио өвчний эмнэлэгт суурилсан тандалтын тогтолцоог үе шаттай нэвтрүүлэх							

32	Хачигт риккетсиоз өвчний тархалтын түвшин (cut off titer) тогтоох тандалт судалгааг бүсчлэн зохион байгуулах						
33	Хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиоз өвчний үлдэцийн судалгааг хийх						
34	Хулгана тахал, Крым-Конгийн цусархаг чичрэг өвчний байгалийн голомтын тандалт судалгааг хийх						
35	Япон энцефалит, Баруун нилийн чичрэг, денге чичрэг, татран, криптоспиридиоз, лейшманиоз, хуурмаг сүрьеэ, хуурмаг ям, ханта вирусын халдвар өвчний байгалийн голомтын илрүүлэг судалгаа хийх						
36	Бабезиоз, Криптоспиридиоз, Баруун Нилийн чичрэг, Денге чичрэг, Ям, Лейшманиоз өвчний хүн амын дундах илрүүлэг (screening) судалгаа хийх						
Дэд зорилт 3.4. Бруцеллэз өвчний тандалтын тогтолцоог бий болгох, оношилгоо эмчилгээний чанарыг сайжруулах							
37	Бруцеллэз өвчний тандалтыг мал эмнэлэгтэй хамтарч хийх						
38	Бруцеллэз өвчний оношилгоо, эмчилгээ, тандалтын чиглэлээр эмнэлзүйч, тархвар судлагч, лабораторийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах						
Зорилт 4. Лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээг хангах, чадавхийг дээшлүүлэх							
Дэд зорилт 4.1. Лабораторийн чадавхийг сайжруулах замаар хүн амд үзүүлэх чанартай лавлагаа тусламж, үйлчилгээг бэхжүүлэх							
39	Бруцеллэз, хуурмаг сүрьеэ, хулгана тахал, боррелиоз, риккетсиоз, ку чичрэг өвчний үүсгэгчийг ялгах, дүйн тодорхойлох аргыг нэвтрүүлэх						
40	Орон нутгийн лабораториудад дархан туяарах урвалыг нэвтрүүлэх, зайн оношилгоонд ашиглах						
41	Хүний бруцеллэз өвчний лабораторийн оношилгоонд нян өсгөвөрлөх, дүйн тодорхойлох аргыг нэвтрүүлэх, стандарт ажлын аргачлал боловсруулах						
42	Спирохет өсгөвөрлөх шинжилгээг турших						

43	Зонхилон тохиолдох хачгаар дамждаг өвчний лабораторийн ялган оношилгооны стандарт ажлын аргачлалыг боловсруулах, нэвтрүүлэх							
44	Эгэл биетэн, шимэгчийн лабораторийн оношилгооны стандарт ажлын аргачлалыг боловсруулах, нэвтрүүлэх							
45	Эс өсгөвөрлөх, шугаман эсийн өсгөврийг тогтворжуулах аргыг турших, нэвтрүүлэх							
46	Зонхилон тохиолдох зоонозын зарим өвчнийүүсгэгчийн молекул-эпидемиологийн судалгаа хийх							
47	Тэжээлт орчин үйлдвэрлэлд хуурайшуулах технологийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх							
48	Рекомбинант технологит суурилсан оношилгооны цомог, урвалж үйлдвэрлэх туршилтыг эхлүүлэх							
<i>Дэд зорилт 4.2. Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх</i>								
49	Лабораторийн чанар, хяналтад MNS/ISO/IEC-17043 стандартыг нэвтрүүлэх							
50	MNS/ISO15189 стандартыг нэвтрүүлж, итгэмжлэгдэх							
51	Лабораторийн гадаад чанарын хяналтын тогтолцоог лавлагаа төв лабораторид нэвтрүүлэх, гадаад чанарын хяналтад хамрагдах							
<i>Дэд зорилт 4.3. Лабораторийн биоэрсдлийн менежментийг сайжруулах</i>								
52	Үндэсний болон орон нутгийн лабораториудад биоэрсдлийн менежментийг үе шаттайгаар нэвтрүүлэх							
Зорилт 5. Судалгаа, шинжилгээнд шинэ дэвшилтэт арга, технологи нэвтрүүлэх замаар нотолгоонд суурилсан үр дүнг ашиглах, үр өгөөжийг тасралтгүй нэмэгдүүлэх								
<i>Дэд зорилт 5.1. Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллах хөшүүргийг бий болгох</i>								
53	Хүний нөөцийн хөгжлийн стратегийг боловсруулах							
54	Үндэсний болон орон нутаг ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг эрдмийн зэрэг горилох, мэргэжлийн зэрэг олгох, дээшлүүлэх сургалтад хамруулах							

Дэд зорилт 5.2. Зоонозын өвчний талаарх судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх						
55	Зоонозын өвчний судалгаа, шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, цар хүрээг өргөжүүлэх, судлаач нарыг үе шаттай бэлтгэх					
56	Гадаад, дотоод хамтын ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох					
57	ШУТ-ийн сан, суурь судалгаа, инновацийн төслөөр хийх судалгааны сэдэв, чиглэлийг тодорхойлох					
58	Олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлүүлэх					
59	Зоонозын өвчний талаар зайн болон ажлын байран дахь сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх					
Дэд зорилт 5.3. Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх						
60	Гадаад, дотоод хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэх					
61	Дотоод, гадаадын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх илтгэл, өгүүллийн тоог нэмэгдүүлэх					
Зорилт 6. Биоаюулгүй байдал, биохамгааллын чадавхийг сайжруулан, биотерроризмын тандалтын тогтолцоог бүрдүүлэх						
Дэд зорилт 6.1. Биотерроризмын тандалтын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх						
62	Биотерроризмын эрсдэлтэй бичил биетний эрсдлийн үнэлгээг хийх, зэрэглэлийг шинэчлэн тогтоох					
63	Биотерроризмын тандалтын тогтолцооны журмыг боловсруулах, тандалтын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх					
64	Биотерроризмын бэлэн байдал, шуурхай арга хэмжээний үед ажиллах зохион байгуулалт, харилцаа холбоо, хамтын ажиллагааг хангах салбар хоорондын журам боловсруулах					
Дэд зорилт 6.2. Биоаюулгүй байдал, биохамгааллын арга хэмжээний чадавхийг сайжруулах						

65	Биотерроризмын бэлэн байдал, хариу арга хэмжээний нэгж байгуулах, бүтэц орон тоог батлуулах						
66	Нэгжийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах, давтан сургах						
67	Биотерроризмын бэлэн байдал, хариу арга хэмжээний чиглэлээр олон улсын түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрш зэргэлдээ улс орнууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах						
<i>Дэд зорилт 6.3. Бйэрсдлийн менежментийн сайжруулах</i>							
68	Лабораторийн тоног төхөөрөмж, урвалж оношлуур, бусад шаардлагатай хэрэгслийг хэрэгцээнд нийцүүлэн бодитой тооцон, улсын төсөвт жил бүр суулгах						
69	Биотерроризмын эрсдэлтэй бичил биетний өсгөвөр, омгийн хадгалалтын технологи, хамгаалалтыг шинэчлэн боловсруулах						
70	ЗӨСҮТ-ийн биоаюулгүй ажиллагааны нөхцлийг сайжруулах, агааржуулалтын системийг бүрэн шинэчилэх						
71	Биотерроризм, биоаюулгүй байдал, биохамгааллын арга хэмжээний талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарсан сургалт зохион байгуулах						
72	Биотерроризм, биоаюулгүй байдал, биохамгааллын арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтнууд, иргэдэд зориулсан гарын авлага, зөвлөмж боловсруулах, түгээх						
73	Биологийн эрсдэлтэй бичил биетний өсгөвөр, омог, сэжигтэй сорьц, материалын савлалт, тээвэрлэлт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах менежментийг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх						
74	Орон нутгийн ЗӨСТ-үүдийн лабораторит хог хаягдлын менежментийн хяналт үнэлгээ хийх						
75	ЗӨСТ-үүдийн харуул хамгаалалтын асуудлыг тухайн аймгийн Засаг даргатай тохиролцон шийдвэрлэх						

76	ЗӨСҮТ-ийн лабораторид хяналтын камер, дохиолол суурилуулах, шинэчлэх				7/11/2017		7/11/2017
77	Биоаюулгүй ажиллагааны зэрэглэлийг нэмэгдүүлэх чиглэлээр Олон улсын байгууллага болон холбогдох байгууллагатай хамтран ажиллах арга хэмжээ авах				7/11/2017		7/11/2017
78	Орон нутгийн ЗӨСТ-ийн лабораторийг биоаюулгүй ажиллагааны тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах						

Эрүүл мэнд, спортын сайд
 2015 оны 03 сарын 02 өдөр
 №... дугаар тушаалын 3 дүг.
 хавсралт

Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн стратегийн чиглэл, 2015-2020 он

2015	2016	2017	2018	2019	2020	Хүрэх үр дүн
<p>Салбар төвүүдийн 50%-ийг зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн сүлжээ тогтолцоонд хамруулна.</p> <p>Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн 3 төвтэй болсон байна.</p> <p>Хүний нооцийн хөгжлийн бодлого боловсрогдож, хэрэгжинэ.</p> <p>15 зоонозын өвчнийг улсын бүртгэлд оруулж, мэдээлдэг болно.</p> <p>Эрт илрүүлэлтийн судалгаа хийгдсэн өвчний эзлэх хувийн жин-15%</p> <p>Тарваган тахал, боом өвчний цогц эрсдлийн үнэлгээ хийгдэнэ.</p> <p>Хачиг устгалын туршилт судалгаа хийгдэж, үр дүнг тооцно.</p> <p>Бүс нутгийн хэмжээнд хачигт риккетсиоз өвчний тархалтын түвшин (cut off titler) тогтоогдоно.</p> <p>ХӨДББайдлын нооцийн хангалт 50 хувьд хүрнэ</p> <p>Хайхардаггүй болон нумуулаар дамжлаг өвчний тандалтын тогтолцоог нэвтрүүлнэ.</p>	<p>68 эрх зүйн баримт бичгийг шинээр болон шинэчлэн батлуулна.</p> <p>Бүх салбар төвүүдийг зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн сүлжээ тогтолцоонд хамруулна.</p> <p>Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн 5 төвтэй болсон байна.</p>	<p>Бүх салбар төвүүдийг зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн сүлжээ тогтолцоонд хамруулна.</p> <p>Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн 5 төвтэй болсон байна.</p>	<p>Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн 5 төвтэй болсон байна.</p>	<p>Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн 5 төвтэй болсон байна.</p>	<p>Орон нутаг дах өвчин өвөрмөц тандалтын загвар бүсийн 5 төвтэй болсон байна.</p>	<p>Орчин үеийн чиг хандлагыг тусгасан эрх зүйн орчны тогтолцоо бүрдэж, Зоонозын өвчний тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, сүлжээ тогтолцоогоор байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төсөв санхүүг оновчтой зарцуулах байдлыг бүрдүүлнэ.</p> <p>Зоонозын өвчний аюул, эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээний чадавх сайжирна. Хайхардаггүй болон нумуулаар дамжлаг өвчний тандалтын тогтолцоог бий болгосноор тандалт, хяналтад байх өвчний цар хүрээ өргөжинө.</p>

Улаанбаатар, Зөвлөх байгуулалт

Хяналт, сэргийлэлт

Зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн стратегийн чиглэл, 2015-2020 он

	2015	2016	2017	2018	2019	2020	Хүрэх үр дүн
Лаборатори судалгаа	Лабораторийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэнэ.						Лабораторийн тусламж, үйлчилгээнд чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, хүн амд үйлчилгээний үр дүн сайжирсан байна.
	Өвчин үүсгэгчийн генотип, полиморфизмын судалгааг өргөжүүлэх, молекул эпидемиологийн судалгааг хөгжүүлэнэ						
	Орон нутгийн лабораториудад ДГУ-ыг нэвтрүүлэх, зайн оношилгоонд ашиглана.						
	Бруцеллэз, хуурмаг сүрьеэ, хулгана тахал, боррелиоз, рикеттсиоз, ку чичрэг өвчний үүсгэгчийг ялгана.						
Эрдэм шинжилгээ, судалгаа	Тэжээлт орчин үйлдвэрлэлд хуурайшуулах технологийг нэвтрүүлэнэ.						Эрдмийн зэрэгтэй судлаачдын хувийн жинг нэмэгдүүлж, олон улсын түвшинд хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо нийт илтгэл, өгүүллийн 40-иос доошгүй хувьд хүрсэн байна.
	Судалгаа шинжилгээний материаллаг баазын хангамж сайжирч, магистрантур, докторантурын судалгаа, шинжилгээний ажлын чанар сайжирна.						
	Нийт мэргэжилтнүүдийн 25 хувь нь эрдмийн зэрэгтэй болсон байна.						
	Гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд 3-4 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэнэ.						
Биологийн судалгаа	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж, хэвлүүлсэн илтгэл, өгүүллийн тоо 1.5 дахин өснө.						Биотерроризмын тандалтын тогтолцооны эхлэл тавигдаж, тэргүүлэх чиглэл тодорхойлогдсон байна. Биоаюулгүй байдал, биоамгааллын арга хэмжээний чадавх сайжирсан байна.
	Биотерроризмын тандалтын чиглэлээр баглагдсан эрх зүйн баримт бичгийн тоо 2-3 дахин нэмэгдсэн байна.						
	Биотерроризмын бэлэн байдал, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх нэгж байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлсэн байна.						
	Биотерроризмын тандалтын чиглэлээр баглагдсан эрх зүйн баримт бичгийн тоо 2-3 дахин нэмэгдсэн байна.						

